

# “Улаанбаатарын зөвшилцөл” Хэлэлцүүлгийн хураангуй



**УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ:  
ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ СУУРЬ ЗАРЧМУУД**

2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр





**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**УЛААНБААТАРЫН ЗӨВШИЛЦӨЛ:**

**ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ  
СУУРЬ ЗАРЧМУУД**

**2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр**

## АГУУЛГА

Нээлтийн үг	- Н.Баяртсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч.....	iii
Илтгэл	- Д.Ган-Очир, Монголбанкны Судалгаа, статистикийн газрын захирал.....	v
Илтгэл	- Нэйл Сакер, ОУВС-ын Монгол дахь суурин төлөөлөгч.....	vi
Хэлэлцүүлэг	- Улаанбаатарын зөвшилцлийг санал болгох нь.....	vii



## Нээлтийн үг

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье. Бидний санаачлагыг дэмжин урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн Та бүхэнд Монголбанкны Ерөнхийлөгчийн хувиар гүн талархал илэрхийлье!

Гурван долоо хоногийн өмнө бид ирээдүйн “Монголын Давос” болох “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган”-ыг Эрдэнэт хотноо “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” сэдвийн дор амжилттай зохион байгуулж Монголын эдийн засгийн энэ жилийн өнгийг тодорхойлсон. Тус чуулганаар бид улс орныхоо эдийн засаг, санхүүгийн секторт ойрын хугацаанд шийдвэрлэх асуудлуудаа ярилцан, нэгдмэл зорилтуудаа тодорхойлж чадсан.

Харин өнөөдөр бид Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгох бодлогын жор болох учиртай “Улаанбаатарын зөвшилцөл”-ийг санал болгон хэлэлцүүлж, Та бүхний үнэтэй саналыг тусгахыг зорьж байна.

Миний бие Монгол улсын эдийн засгийн шийдвэр гаргалт, бодлого боловсруулалт, соён гэгээрүүлэх чиглэлээр олон жил ажиллаж, зүтгэж явахдаа хуримтлуулсан мэдлэг, туршлага, санал бодлоо нэгтгэн, өөрийн санаачлан байгуулсан “Мөнгө, санхүү, баялаг” судалгаа, шинжилгээний сэтгүүлээр дамжуулан “Улаанбаатарын зөвшилцөл”-ийн төслийг санал болгон эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчдын оюуны сонорт хүргэсэн билээ. Монголбанк хэлэлцүүлгийн индэр болоход бэлэн байгаагаа уламжилсны дагуу өнөөдрийн энэ арга хэмжээг зохион байгуулж байна.

Монгол улс сүүлийн 300 гаруй жил бие даасан эдийн засгийн бодлогогүй явж ирлээ. 1636-1911 оны хооронд 200 гаруй жил Монгол орон Манж Чин улсын харьяанд явж ирсэн. Тухайн үед үндэсний мөнгөн тэмдэгтгүй байсан бөгөөд Орос, Хятадын мөнгөн тэмдэгтүүд, Англи, Америк, Мексикийн алт, мөнгөн зооснууд, гулдмай мөнгө, хятад ембүү, амьтны үс, хадаг, цай, хонь мал зэргийг арилжаанд ашиглаж байв. Гадаадын пүүсүүд л худалдаа эрхэлж байсан бөгөөд гадаад пүүсүүд, феодал ноёд ард түмний мөнгийг хүүлж байв. 1921 оны Ардын хувьсгалын ялалтын үр дүнд харийн түрэмгийлэгчдийг хөөн гаргаж, феодалын байгууллыг халж, Ардын эрхт цаазат Монгол улсыг тунхагласан. Үүнээс хойших 70 жилд Монгол Улс бие даасан бодлого боловсруулан хэрэгжүүлэхээс илүүтэй улс төр, эдийн засаг, худалдаа, цэрэг, геополитикийн бодлогууд дээр Зөвлөлт Холбоот улсын тусламж дэмжлэгтэйгээр явж ирсээр 1990 оны Ардчилсан хувьсгалтай золгосон.

Ардчилсан хувьсгалын дараагаас манай улс ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжсэн билээ. Зэх зээлийн эдийн засагт шилжсэн эхний он жилүүдэд буюу 1991-1993 оны хооронд эдийн засаг жилд дунджаар 7 орчим хувиар унасан билээ. Энэ үеэс л олон улсын санхүүгийн байгууллагууд, донор орнуудын тусламж, дэмжлэгийг авч эхэлсэн. Тухайлбал, Монгол улс 1991 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Олон улсын валютын сан (ОУВС)-д элссэн бөгөөд үүнээс хойших 27 жилийн хугацаанд Монгол улс ОУВС-ийн хөтөлбөрийг 6 удаа авч, нийт 13 жилд нь тус сангийн хөтөлбөртэй явсаар өнөөдөртэй золголоо. Тухайлбал, 1991 оны 10 дугаар сарын 4-ний өдөр “Стэнд бай” хөтөлбөрийг 1 жилийн хугацаатай авч хэрэгжүүлснээр донор орнуудын зээл, тусламжийг ашиглах нөхцөлийг бүрдүүлж байв. Үүний дараагаар “Enhanced Structural Adjustment Facility (ESAF)” хөтөлбөрийг 1993 онд 3 жилийн хугацаатай, “ESAF 2” хөтөлбөрийг 1997 онд 3 жилийн хугацаатай, ядуурал 36 хувьтай байсан тул 2001 онд “Poverty Reduction and Growth Facility (PRGF)” хөтөлбөрийг 3 жилийн хугацаатай, “Стэнд бай” хөтөлбөрийг 2009 онд 18 сарын хугацаатай тус тус авч хэрэгжүүлсэн. Харин 2017 оны 5 дугаар сараас “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаатай авч, одоо хэрэгжээд явж байна.



**Н.Баяртсайхан**

Монголбанкны  
Ерөнхийлөгч

**“Гадаад  
валютын  
хангалттай  
нөөц нь улс  
орны тусгаар  
тогтнол,  
аюулгүй  
байдал,  
үндэсний  
мөнгөн  
тэмдэгтийн  
баталгаа мөн”**

Зах зээлийн эдийн засагт шилжсэн он жилүүдэд эдийн засгийн бодлогын ноцтой алдаануудыг ч гаргасаар ирэв. Сүүлийн жилүүдэд төсвийн сахилга бат алдагдаж, манай улс нэгдсэн төсөв, концесс, хөгжлийн банкны санхүүжилт болон Монголбанкны санхүүжилт гэсэн 4 давхар “төсөвтэй” явж ирсэн нь төсвийн болон төлбөрийн тэнцлийн хос алдагдал, гадаад өрийн тогтворгүй байдал, гадаад валютын нөөц шавхагдах, үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ унах зэрэг эдийн засгийн эмзэг хүнд байдалд хүргэснийг жил гаруйн өмнө бид бүгд харсан. **“Гадаад валютын хангалттай нөөц нь улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний мөнгөн тэмдэгтийн баталгаа мөн”** гэсэн энэ үгийг үе үеийн бодлого боловсруулагчид байнга санаж явах учиртайг би энд онцлон хэлмээр байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа баримталбал бид 1 жилийн импорттой тэнцэх буюу дор хаяж 6-7 тэрбум ам.долларын гадаад валютын нөөцтэй байх учиртай .

Бодлогын өмнөх алдаануудаас харахад тогтвортой эдийн засгийн бодлого, төрийн бодлогын залгамж халаа манай оронд үгүйлэгдэж байна. Нөгөөтээгүүр, Монгол улсын хувьд улс төр нь өөрөө эдийн засгийн тогтворгүй байдлын эрсдэлийг дагуулсаар ирлээ.

Энэ бүгдийг харгалзан үзээд эдийн засгийн цаашдын тоглолтын дүрмээ тодорхой болгох нь энэ цаг үед юу юунаас илүү чухал гэж үзэж байна. Иймд олон улсын туршлага, бидний туулж ирсэн зам, улс орны онцлог байдлыг харгалзан Монгол улсыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх “Улаанбаатарын зөвшилцөл”-ийг Монголбанк дараах 8 зарчмын хүрээнд томъёолон хэлэлцүүлж байна:

- Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авилгалын эсрэг тууштай тэмцэх,
- Дэлхий ертөнц бүхэлдээ шинэ хөрөнгө оруулалтын төлөөх тулааны талбар болсон энэ үед гадаадын шууд болон хувийн хөрөнгө оруулалтыг тууштай даллан дуудах,
- Төсвийн сахилгыг хангах, үндэсний хуримтлалтай болж, тууштай нэмэгдүүлэх, бодит эдийн засаг, инфляцыг тогтворжуулах,
- Эдийн засгийн дархлааг хангах хэмжээнд гадаад валютын нөөцийг хуримтлуулах, өрийн дарамтад орохоос сэргийлэх,
- Хүчтэй санхүүгийн салбартай болох, санхүүгийн зах зээлийг зохистой төвшинд либералчлах, өрсөлдөөн бий болгох,
- Аж үйлдвэржилтэд түүчээлэх, гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай зүтгүүр хэдэн компанийг бий болгож дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх,
- Дэлхийн болон бүс нутгийн дэд бүтцийн том хөтөлбөрүүдэд багтаж орох, газар нутгийн байршлын давуу талаа ашиглах, орон нутгууд тэгш хөгжих боломж бүрдүүлэх,
- Байгалийн баялаг-аа оновчтой байдлаар эдийн засгийн эргэлтэд оруулах, “Баялгийн хараал”-аас зайлсхийх зэрэг асуудлыг дурдаж болно.

Энэхүү зөвшилцөл нь улс төрийн орчноос үл хамааран Монгол улсын хөгжлийн бодлогод тогтвортой хадгалагдан хэрэгждэг байгаасай хэмээн бид хүсч байгааг энд онцлон хэлэхийг хүсч байна.

Иймээс Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид та бүхнээс Монголыг тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх зам болох учиртай “Улаанбаатар зөвшилцөл”-ийн төслийг боловсронгуй болгоход эрдэм, оюунаа чилээн, хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

Удахгүй ирэх “Нөхөрсөг хэмээх шар нохой” жилдээ “Улаанбаатар зөвшилцөл”-ийг тунхаглан золгож, сахин хамгаалж, түгээн дэлгэрүүлэхийн ерөөл дэвшүүлье. Та бүхэнд баярлалаа!

## Улаанбаатарын зөвшилцөл - Хөгжилд хүргэх бодлогын жор

Манай орны хувьд эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгох нь НҮБ-аас дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах, орлогын түвшний ангиллыг дээшлүүлэх, Монгол иргэн бүрийн амьдралын чанарыг дээшлүүлэх боломжийг олгоно. Сүүлийн 10 гаруй жилд эдийн засгийн мөчлөг богино давтамжтай буюу өрнөл-уналтын мөчлөг 3-4 жил тутам тохиолдож байна. ДНБ-ий жилийн дундаж өсөлт 1991-2016 онд 4.4 хувь байлаа. Эдийн засгийн өсөлт хэт өндөр хэлбэлзэлтэй, гадаад цочролоос хэт их хамааралтай байна. Эдийн засгийн өсөлтийн өндөр хэлбэлзэл нь өрхийн хэрэглээний өсөлтийг савлуулж, өрхийн өрийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг тогтвортой бууруулах зэрэг нийгмийн зорилтыг хангах боломжийг хязгаарлаж байна. Эдийн засгийн өсөлтийг тогтвортой, хүртээмжтэй болгох асуудал нь гадаад цочролоос дархлаатай болгох, эдийн засгийн бүтцийг ажлын байр олноор бий болгодог олон тулгууртай болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг нь бидний хувьд сорилт, тулгарч буй бэрхшээл болж байна.

Эдийн засгийн өсөлтийн динамикийг сайтар ойлгохын тулд түүнд нөлөөлөх хүчин зүйлс, бодлогын нөлөөг авч үзэх ёстой. Rodrick (2003) өсөлтийн эдийн засгийн онолыг системтэй тайлбарлахын тулд өсөлтийн “барагцаалсан тодорхойлогч” болон “гүнзгий тодорхойлогч”-ийг хооронд нь ялгах шаардлагатай гэж үзсэн. Барагцаалсан тодорхойлогч нь орлогод юу нөлөөлөх вэ? гэдэг асуултад хариулах стандарт хүчин зүйлс (биет болон хүмүүн капиталын хуримтлал, бүтээмж) хамаардаг бол гүнзгий тодорхойлогч гэдэгт ерөнхий утгаараа газар зүйн байршил, интеграц (худалдаа), институцийг хамааруулж дурдаж болно.

Улс орнуудын эдийн засгийн өсөлтийг түүхэн байдлаас аваад үзэхэд харилцан адилгүй байсан нь өнөөдрийн хөгжлийн ялгаа, орлогын тэгш бус байдлыг бий болгоход нөлөөлсөн ажээ. Эдийн засагчид өсөлтийн ерөнхий динамик, зарчмыг тодорхойлж байгаа хэдий ч чухам юунаас шалтгаалан өсөлтийн том ялгаа бий болж байгааг бүрэн тайлбарлаж чадахгүй хэвээр л байна. Өмнө хэлсэнчлэн институци, бодлого, интеграц, соёл иргэншил, газар зүйн байршил зэрэг нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч суурь хүчин зүйлс гэсэн үзэл баримтлал одоогоор давамгайлж байна. Эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлтийг бий болгохын тулд бодлого боловсруулагчдаас хамаарах хоёр хүчин зүйл нь: 1) тухайн оронд шаардлагатай төрийн сайн бодлого; 2) институцийг сайжруулах явдал юм.

Монгол улсын хувьд эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгохын тулд өөрийн орны онцлог давуу талд суурилсан салбарыг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх явдал туйлын чухал байна. Энэ том сорилтыг амжилттай даван туулахын тулд харилцан нийцтэй макро эдийн засгийн болон бүтцийн тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд мэдлэг, боловсролтой иргэд, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хүчтэй институцийг бүрдүүлэх нь чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Олон улсын туршлага, өмнөх цуврал судалгаа (Н.Баяртсайхан 2017, Д.Ган-Очир 2017a,b), өөрийн орны онцлог байдалд тулгуурлан Монгол улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжилд хүргэх “Улаанбаатарын зөвшилцөл” (Ulaanbaatar Consensus)-ийг бид Монголбанкны Ерөнхийлөгчийн дурдсан 8-н зарчмын хүрээнд санал болгож байна.



**Д.Ган-Очир**

Судалгаа,  
статистикийн газрын  
захирал, Монголбанк

... өөрийн орны  
онцлог давуу  
талд суурилсан  
салбарыг  
хөгжүүлэх  
замаар эдийн  
засгийг  
төрөлжүүлэх  
явдал туйлын  
чухал ...

## “Улаанбаатарын зөвшилцөл”-д өгөх санал дүгнэлт



**Нэйл Сакер**

ОУВС-ын Монгол дахь суурин төлөөлөгч

**Бодлогыг зөв тодорхойлон хэрэгжүүлснээр Монгол Улс урт хугацаандаа тогтвортой өсөх боломжтой.**

“Улаанбаатарын зөвшилцөл” хэлэлцүүлэгт урьсан Монголбанкны Ерөнхийлөгчид талархал илэрхийлье. Энэхүү хэлэлцүүлгээр чухал сэдвийг хөндөн ярьж байна. Эдийн засгийн өсөлт болон хөгжлийн бүтцийн талаар ярилцах нь зөв арга гэж үзэж байна. Хувийн хэвшил болон хөрөнгө оруулагчдын хувьд бодлогын чиглэлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Бодлогыг зөв тодорхойлон хэрэгжүүлснээр Монгол Улс урт хугацаандаа тогтвортой өсөх боломжтой. Ингэснээр амьдралын түвшин сайжирч, ядуурал, орлогын ялгаа багасна. Мөн бодлогыг оновчтой зөв тодорхойлж, тууштай хэрэгжүүлэх нь амжилтын түлхүүр юм. Бүх нийтийн дэмжлэг авахын зэрэгцээ үр өгөөж хүн бүрд хүрсэн байх ёстой.

*Эдийн засгийн гол бодлогууд:*

1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, өрийн хэмжээг бууруулах, эрсдэлээс хамгаалж нөөц бүрдүүлэх:
  - Төсвийн бодлогыг тодотгож хэлэх нь зүйтэй гэж бодож байна. Засгийн газар төсвийг танах хэрэгтэй. Өнгөрсөн жилүүдэд эдийн засаг тогтвортой байх үед Засгийн газар зарлага их гаргаж өр их тавьсан. Тиймээс өр тавихаас сэргийлэх хэрэгтэй байна. Гадаадын цэвэр албан нөөц өсч байгаа нь зэрэг нөлөө харуулж байна.
  - Мөнгөний бодлого,
  - Уян хатан ханштай байх нь чухал.
2. Нийгмийн халамжийг орлогод суурилан зорилтот бүлэгт чиглүүлж ядуу эмзэг бүлгийг хамгаалах,
3. Санхүүгийн системийг эрүүл байлгах:
  - Өрсөлдөх чадвартай санхүүгийн салбарыг бий болгож,
  - Үндэслэл сайтай хүүгээр зээл олгож, эдийн засгийн өсөлтийг дэмжих
4. Өрсөлдөх чадварыг сайжруулах
  - Бизнес, хөрөнгө оруулалтын орчин нь дэмжлэг болох ёстой
  - Хүний болон биет капиталын зохистой хөгжлийг хангах
  - Төрөлжүүлэх бааз суурийг бүрдүүлэх.

*Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд гарсан ахиц дэвшил:*

Хөтөлбөрийн явц сайн байна. ОУВС зөвхөн зөвлөгөө, санхүүжилтээр дэмжин тусалж байна. Монгол улс ОУВС-аас өгсөн зөвлөмжүүдийг дагах нь зөв байна. Сайн макро эдийн засгийн бодлоготой байж, төсвийн алдагдлыг их хэмжээгээр бууруулсан нь сайшаалтай. Эдийн засагт итгэх итгэл сайжирснаар шинэ хөрөнгө оруулагчид нэмэгдэж, банкууд зээл олгож эхэлсэн. Шинэ засгийн газар хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэхээ мэдэгдсэн бөгөөд Улаанбаатар зөвшилцлийн үндсэн зарчмуудаас олныг хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн гурав дахь үнэлгээг саяхан эерэг дүгнэлээ:

- Гол зорилтот үзүүлэлтүүд (үүнд төсвийн үр дүн болон гадаад валютын нөөц) хангагдсан.
- Гадаад орчин таатай байж, эдийн засагт итгэх итгэл сайжирснаар эдийн засаг сэргэж байна.
- Банкны салбарыг бэхжүүлэх, төсвийн бодлого тодорхойлох тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн бодлогыг дэмжих нь ойрын хугацаанд анхаарлын төвд байна.
- Урт хугацааны өсөлтийн бааз суурийг бүрдүүлж, тэлэлт-агшилтын мөчлөгийг таслан зогсоох зорилго бүхий бүтцийн шинэчлэлийн чухал арга хэмжээнүүд хэрэгжиж байна.
- Эрх баригчдын зүгээс шинэчлэлийн арга хэмжээний эрчмийг алдагдуулалгүй үргэлжлүүлэн урт хугацааны үр өгөөжийг бэхжүүлэх тууштай байр суурьтай байгааг дэмжиж байна.





Хэлэлцүүлгийн модератор:  
**Б.Лхагвасүрэн**

Монголбанкны дэд ерөнхийлөгч

“Улаанбаатарын зөвшилцөл” гэдэг их чухал санаачлагыг гаргаж ирж байгаа явдалд маш сайшаалтай хандаж буйгаа илэрхийлье. Бид том төслүүдээ хөдөлгөө, нефть үйлдвэрлэх, импорт орлох үйлдвэрүүд барья, аж үйлдвэрийн бүсүүдээ байгуулаад Монгол улс хүнд үйлдвэртэй больё зэрэг бидний хөгжлийн төсөөллийн хувьд бодит баримтууд дээр тулгуурлан харвал ийм зарчмаар явах ёстой болж байгаа төдийгүй энэ нь мөн хуульчлагдаад явах ёстой гэж үзэж байна.

2017 оны статистик мэдээлэлд үндэслэн эдийн засгийн идэвхтэй хүн амаас ажилгүй иргэдийн тоог хасаад эдийн засгийн идэвхгүй хүн ам дээр нэмээд нийт хүн амын тоонд хуваан үзэхэд сүүлийн 5-6 жил ажилгүйдлийн түвшин 80 хувьтай гарахаар байна. Энэ бол Монгол улс халамжийн улс буюу хүнийг илүү ажиллахгүй байх тусам нь дэмждэг бодлогыг барьж ирсний уршиг гэж үзэж болно. Өнөөгийн энэ орчинд бид институцийн чанар, засаглалын чанарыг хөндсөн энэхүү 8 зарчмыг гаргаж тавьж байгаа учир эдгээрийг хэрэгжүүлэх, хэвшүүлэхэд багагүй саад бэрхшээлтэй учирна. Бид бодлогын болон сэтгэлгээний өөрчлөлтийг нийгэмд бий болгох шаардлагатай учир уг зөвшилцөл маш чухал ач холбогдолтой зүйл юм.

Улаанбаатарын зөвшилцөл хэлэлцүүлэгт дэвшүүлсэн зарчмуудын хувьд өнгөрсөн 27 жилийн эдийн засгийн түүхэн онцлог дээрээ суурилсан, эдийн засгийн онолын түүхэн хувьслыг үнэлж дүгнээд ийм 8 зарчим гаргаж ирсэн гэж үзэж байна. Энэ бол бид цаашдаа эдийн засаг болон нийгмийн хувьд юуг тэргүүн эгнээд тавьж хэрэгжүүлэх хэрэгтэй вэ гэсэн заавар зарчим болж байна. Цаашдаа үүнийг засаж сайжруулаад явахад хүн нэг бүрийн оролцоо чухал үүрэг гүйцэтгэнэ.

Эдийн засагч Дэнни Родрих (2015)-ын “Эдийн засгийн дүрмүүд” судалгааны ажил дээр яг энэ төрлийн зарчмуудын талаар судалсан байдаг. Түүний хувьд энэхүү зарчмуудын хэрэгжихэд хүндрэлтэй нөхцөлүүдийг томъёолсноос гадна түүнээс гарах гаргалгааг шийдвэр гаргалтын мод гэдэг зүйлээр тайлбарласан байдаг. Үүний адилаар бид эдгээр зарчмууд дээр шийдвэр гаргалтын модыг бий болгож, эдгээрээс тэргүүн зарчмаа тодорхойлох ёстой.

Манай улсад хамгийн их дутагдаж буй хөгжлийн стратегийн зарчим бол нэгдүгээрт хүртээмжтэй өсөлтийн зарчим, хоёрдугаарт институци болон засаглалын чанар гэж харж байна. Бусад орнуудын жишгээр зарчим тус бүрийн хувьд эрэлтийн болон нийлүүлэлтийн гэсэн дэд ангилал үүсгээд түүнийгээ баримтлаж ажиллах ёстой. Олон эдийн засагч, судлаачдын эрэл хайгуул дундаас Н.Баяртсайхан, Д.Ган-Очир нар дээр дурдсан 8 зарчмыг гаргаж ирж байгаа нь маш том ололт юм.

Бид хөгжил, эдийн засгийн стратеги ярьж байгаа үед цаашид Монголын эдийн засагт тулгарах дараах 2 сорилтыг зайлшгүй анхаарах хэрэгтэй. Нэгдүгээр сорилт бол хүн ам зүйн асуудал. Монгол улсын хувьд хүн ам цөөн, эрүүл биш, боловсрол тааруу байна. Н.Баяртсайхан болон Д.Ган-Очир нарын илтгэлд дурдагдсан баялгийн хараал гэдэг зүйл үүнээс үүдэлтэй байж болно. Мөн хүн ам цөөний дээр боловсорсон цөөн хэсгийн тархийг ашиглах институцийн орчин байхгүй байгаа нь хүн ам зүйн хараал болж улмаар баялгийн хараалтай уялдаж байж болзошгүй. Дараагийн сорилт нь баялагт хандах төрийн хандлага давамгайлсан явдал. Улс орны бүх баялаг төрөөр дамжиж байгаа энэ үед институцийн чанар, засаглалын чанар гэдэг зүйл хамгийн тэргүүн эгнээд тавигдах ёстой гэж үзэж байна.

Ингээд энэхүү чухал санаачлагыг хөндсөн Монголбанк болон хоёр судлаачдаа маш их баярлаж буйгаа илэрхийлье.



**С.Дэмбэрэл**

Зах зээл судлалын  
хүрээлэнгийн ТУЗ-ын  
дарга

**Манай улсад  
хамгийн их  
дутагдаж буй  
хөгжлийн  
стратегийн  
зарчим бол  
нэгдүгээрт  
хүртээмжтэй  
өсөлтийн зарчим,  
хоёрдугаарт  
институци болон  
засаглалын  
зарчим юм.**



Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Бид аливаа зүйлийн эдийн засгийн онолын үндэслэлийг харж үзэж байх ёстой. Бидний эдийн засгийн онол, судалгаанд авч үздэг таамаглалууд хэрэглэгдэхээ больчихсон. Үр ашигтай зах зээл гэдэг зүйл бол сураггүй болсон. Тийм зүйл байдаггүй бөгөөд түүнийг зохицуулахгүй бол болохгүй гэдгийг бүгд одоо ойлгосон хэдий ч яаж зохицуулах вэ гэдгийг хэн ч мэдэхгүй байгаа. Мөн хүн өөртөө ашигтай шийдвэрийг гаргадаг рациональ байх таамаглал байхгүй болсон. Харин ч сүүлийн Нобелийн шагналыг хүн бол иррациональ байдаг гэсэн онолд өгсөн байгаа. Энэ мэтчилэн суурь таамаглалууд их өөрчлөгдөж байгаа учраас эдийн засгийн шинжлэх ухаан бүхэлдээ өөрчлөгдөж байна. Ялангуяа, 2007-2008 оны хямралаас хойш юу зөв гэдэг талаар эргэлзэж, шинэ сурах бичиг ч гаргаж чадахаа болиод байгаа.

Бид аливаа зөвшилцлийг явуулахад ямар нэгэн абстракцийн түвшин байх ёстой. Үүнийг тухайн улс орныхоо түүхэн нөхцөл байдалд уялдуулж томьёолох нь чухал юм. Манай нөхцөл байдалд яаж томьёолж болох вэ гэвэл, миний харж буйгаар хэд хэдэн чухал асуудал байгаа.

*Өмчийн эрхийн асуудал:* Өнөөдөр өмчийн эрхийг маш тодорхой болгох хэрэгтэй. Хувийн өмч бол халдашгүй юм, хувийн өмчид бүү халд гэж тодорхой хэлэх ёстой. Энэ бол хамгийн чухал зүйл болоод байна. Өнөө цагт хувийн өмчийг өсгөж үржүүлэх, арвижуулах бололцоог ард иргэддээ олгохгүй, өмчийг нь булааж дээрэмдэж байгаа нь буруу юм.

*Хэлцэл:* Аливаа гэрээ хэлцэл байгуулчихсан байхад төр нь өөрөө орж ирж түүнийг нь булаадаг, түүнийхээ тулд өөртөө зориулж хууль гаргадаг, тэр хууль нь хэрэгжих ямар ч баталгаа байхгүй байдаг. Ямар ч үндэслэлгүй хуулийг УИХ баталчихаад түүнийгээ хэрэгжүүл гэж шаардаж бусад төрийн институтуудаа хүнд байдалд оруулдаг.

Тэгэхээр өнөөгийн Монголын нөхцөл байдалд абстракцийн түвшинг томьёолохдоо хувийн өмч бол халдашгүй, мөн хэлцлийн тухай асуудал чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байна.

Бодит эдийн засгийн сектор луу ороход, манай үйлдвэр, аж ахуйн газруудын өсөж дэвших ганц арга зам нь гадаад зах зээл л болж байна. Тиймээс бизнесийнхнийг гадаад зах зээл, ялангуяа хоёр хөршдөө гарах эрх зүй, санхүүгийн орчинг бүрдүүлэх, тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийг тууштай дэмждэг байх тал дээр зөвшилцөх хэрэгтэй.

Төр засаг өөрийн гаргаж байгаа алдаатай буруу шийдвэрүүдээ бизнесийнхэн рүү түлхдэгээ болих хэрэгтэй. Төр иргэний өмнө хариуцлага хүлээдэг тогтолцоо байх ёстой. Энэ бол үндсэн хуулинд заасан тодорхой зүйл боловч үүнийг хэрэгжүүлдэг механизм өнөөдөр байхгүй байна. Тэгэхээр төр иргэнийхээ өмнө хариуцлага хүлээдэг байх тал дээр зөвшилцөх нь зүйтэй.

Энэ бүгдийг дүгнээд хэлэхэд өнөөгийн нөхцөл байдалд төрийн оролцоо минимал байг, засаглал максимал байг. Ийм байдлаар томьёолоод явбал эдийн засгийн өнөөгийн тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх нэг алхам болох болов уу гэж бодож байна. Дахин хэлэхэд онолын таамаглал гэдэг зүйл байхгүй болж байгаа гэдгийг анхаараарай, мөн аливаа асуудлыг зөвшилцөхдөө өнөөгийн нөхцөл байдалдаа таарсан абстракцийн түвшинг тодорхойлох хэрэгтэй. Баяртсайхан ерөнхийлөгчдөө баярлалаа.

## Р.Амаржаргал

МУ-ын 21 дэх Ерөнхий сайд, эдийн засагч

... Монголын  
нөхцөл  
байдалд  
абстракцийн  
түвшинг  
томьёолохдоо  
хувийн өмч бол  
халдашгүй,  
мөн хэлцлийн  
тухай асуудал  
чухал гэдгийг  
хүлээн  
зөвшөөрөх  
хэрэгтэй ...

Та бүхэнд энэ өдрийн халуун мэндийг хүргэе. Зөвшилцөл хийж буй нь сайн хэрэг гэхдээ энэ нь завшилцал байж болохгүй. Гэмт хэрэгтнүүдийг нуудаг, эдийн засагт муу зүйлс хийсэн, улс төрийн том алдаа гаргасан хүмүүсийг энэ нэрийн дор нуудаг байж болохгүй. Улс төрчдийн хийсэн макро эдийн засгийн бүх алдаа, дутагдлыг ард иргэд, хувийн аж ахуйн нэгжүүд үүрээд гардаг. Өнөөдөр улс орныг хэдэн их наядын алдагдалд оруулсан нэг ч улс төрч ямар нэгэн төлбөр төлдөггүй, хариуцлага хүлээдэггүй. Харин албан тушаал аваад, томилогдоод, сайд дарга болоод явдаг.

Өмнөх Монголбанкны удирдлагын үед буюу 2013 оны үед эдийн засгийн өсөлт -1 хувьтай, нүүрсний үнэ 5 дахин унасан, хөрөнгө оруулалтын урсгал саарсан байхад энэ их хөрөнгө оруулалтыг хангахын тулд тэр үеийн хийсэн зүйлс зөв байсан ч улстай нийлж хууль бус гэрээ байгуулж, хууль бусаар 6 яаманд 2.7 их наяд (1.5 их наяд ам.доллар) төгрөг тараасан байдаг. Тэр үйл явдал хэрэв үнэхээр зөв байсан бол тэр гавьяаг хэлээд эс бөгөөс үнэхээр мэргэжлийн биш байгаад, улс төрчидтэй нийлээд өр төлбөр үүнээс болж нэмэгдсэн гэвэл хариуцлагыг нь хүлээлгэх хэрэгтэй. Өнөөдрийн 5.1 хувийн эдийн засгийн өсөлт зөвхөн ОУВС болон Засгийн газрын гавьяа биш. Сүүлийн 3 жилд буюу 2014 оноос эхлээд мөнгөний бодлого бус сангийн бодлого хэрэглэж эхлээд, ил тодын хууль гаргаад, НӨАТ-ын системд шилжиж байж өнөөдрийн энэ татварын орлого бий болох нөхцөл бүрдсэн гэдгийг санах хэрэгтэй.

Монголбанк өнгөрсөн 2017 онд 20 тонн алт худалдан авсан. Аж ахуйн нэгжүүд Монголбанкинд 2.5 хувийн татвараар алтаа тушаачихсан байтал одоо дахиад прокурор очоод явж байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмүү өртгийн албан татвар гээд олон төрлийн татварууд нэмэлтээр шахаж шаардаад, орлогын эх үүсвэрийг нь шалгаад явж байна. Одоо яг энэ зүйл дээр зөвшилцөөд, тэр асуудлуудыг шийдэх хэрэгтэй. Хэрэв дараа жил энэ асуудал үргэлжлээд явбал Монголбанк 20 байтугай 2 тонн алтыг ч худалдан авч чадахгүй. Энэ мэт дотоод оношоо зөв тавьж, эмчилгээгээ зөв хийгээд явах зарчмын заалтуудыг зөвшилцөлдөө тусгах явдал маш чухал байна.

Өнгөрсөн хугацаанд бид үнэхээр онолгүй, эрдэм номгүй явж ирсэн нь үнэн. Өнөөдрийн хямрал бол худалдааны хямрал. Өнөөдөр 30 мянган орон сууц зарагдахгүй байна, 32 сая тонн нүүрсний таваарын үнэлгээг өсгөж чадахгүй байна, 14 сая малын арьс ширээ зарж чадахгүй байна. Энэ бол Дэмбэрэл дарга бид хоёрын хүмүүст зөвлөж өгч чадаагүйн алдаа. Яагаад гэвэл бидэнд худалдааны онол, энэ талын зөвлөмж нэгдсэн онол байхгүй байна. Хөрөнгө оруулалтын оновчтой шийдлийн талаарх зөвлөмж байхгүй байсан. Одоо бид СЭЗИС-тай хамтран татварын, худалдааны талаарх онол, зөвлөмжүүдийг боловсруулаад ажиллаад явж байна.

Мөн төрийн өмч яг өнөөдөр хуульгүй байна, төрийн өмчийн нийтийн хамгаалалтын хууль алга, төрийн өмчийн төлөөх тэмцэл биднийг хямрааж байна.

Хоёрдугаарт аж ахуй эрхлэх эрхийн тухай хуулийг гаргаж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл аж ахуй нэгжийг үйл ажиллагаа эрхлүүлэх гэж байгаа бол эрхийг нь хамгаалдаг байх хэрэгтэй. Лиценз өгсөн нэрээр төрийн дарга нар очиж дарамталдаг, бензиний үнэ буулгасангүй хэмээн дарамт үзүүлдэг байж болохгүй. Энэ эрхийг авахын тулд бид 1992 онд хувьсгал хийсэн. Монгол улсын судлаач эрдэмтэд салбар салбартаа эрдмийн оргилд хүрч чадаагүй байна. Хуурамч дипломтой, нэг судалгааны ажлаа насан туршдаа ярьдаг зүйлс ажиглагдаад байна.

Нэгдүгээр асуудлын хувьд буюу “Засаглал, институцийг сайжруулж, чанарыг бэхжүүлэх, авилгын эсрэг тууштай тэмцэх” гэдэг заалт маш хэцүү юм шиг санагддаг. Миний хувьд авилга авч үзээгүй, өгч үзээгүй хүн энэхүү асуудлыг авч явах ёстой юм шиг санагддаг. Одоогийн улс төрчдөөс тийм хүн олоод ир гэвэл нэг ч олдохгүй юм шиг санагддаг. Ингээд өнөөдрийн хэлэлцүүлэгт урьсан явдалд талархал илэрхийлье. Баярлалаа та бүхэнд.



## Б.Лхагважав

МҮХАҮТ-ын Удирдах зөвлөлийн дарга бөгөөд Ерөнхийлөгч

Аж ахуй нэгжийг үйл ажиллагаа эрхлүүлэх гэж байгаа бол эрхийг нь хамгаалдаг байх хэрэгтэй.



**Дэлгэрийн Чойрын хийдийн хамба Зава Дамдин Ренбучи**

Та бүгдийн амар амгаланг айлтгая. Тэнгэрийн санаа бол ардын сэтгэлд байдаг гэдэг эртний сайхан үг бий. Үүний дагуу намайг шашны төлөөлөл биш ардын төлөөлөл болгож урьсан байх.

Хүн бүр хөдөлмөрлөж, дор бүрнээ эдийн засгаа сайжруулахад, улс орноо хөгжүүлэхэд гар бие оролцох хэрэгтэй. Биднийг зүгээр сууж байхад бусад их гүрнүүд туслах юм шиг суугаад байж болохгүй. Одоо тусалж байгаа улс орнууд, байгууллагуудаас авсан зээлээ цаг хугацаанд нь буцаан өгч зээлийн нэр хүнд гэдэг зүйлийг дор бүрнээ бодолцох хэрэгтэй. Бид дэлхийн бусад улс орнуудаас орж ирж буй зээл тусламж болон бусад хөрөнгийг зөв удирдан зохицуулж эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтөд чиглэсэн оновчтой хөрөнгө оруулалтуудыг хийх нь зөв. Хөрөнгийг зөв удирдаж, өсгөж чадахуйц чадварлаг хариуцлага хүлээх чадвартай мэргэжилтнүүдийн ур чадварыг ашиглан бусад улс орны туршлагаас судлуулж өөрийн улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломж байгаа харагддаг. Хүн бүр Монгол улсын нэрийн өмнөөс бусад улс орнуудтай харьцахдаа өөрийн улсын нэр хүндийг хамгаалж ганц өнөөдрөө биш ирээдүйгээ хараасай. Бид бусдаар тэтгүүлэх гэж биш, харин тэгш хэмжээнд харилцаж чаддаг, бусдад үнэлэгдэх чадвартай байж бусад улс орнуудын дунд толгой дээгүүр алхаасай гэж хүсч байна.

Өнөөдрийн зөвшилцлөөр санал болгож буй 8 саналыг илүү нарийн болгох хэрэгтэй гэсэнтэй санал нэг байна. Энэ 8 зарчмыг хөгжлийн зорилт болгож тавих саналтай байна. Тухайлбал, тодорхой хугацаанд Монгол Улс зорилт тавьж ядуурлыг ямар хэмжээнд аваачих, ажлын байрыг хэрхэн нэмэгдүүлэх, төрөлжилтийг хэрхэн хангах зэргээр хөгжлийн зорилт болгон түүнд хүрэх хөгжлийн загварыг бий болгох саналтай байна. Бусад орны хөгжлийн хандлагаас харахад өөрийн улсад тохирсон холимог онолуудыг сонгосон байдаг. Харин Монгол улсын хувьд ямар онол тохирох талаар дотроо ярилцаж холимог байдлаар тодорхойлох нь зөв гэж үзэж байна.

Засгийн газрын бүтцийн чиг үүргээр Үндэсний Хөгжлийн газар Монгол Улсын дунд, урт хугацааны бодлогыг тодорхойлох, салбарын бодлогын хоорондын уялдааг хангах чиг үүрэгтэй ажиллаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны загварыг боловсруулахаар ажиллаж байна. Засгийн газрын түвшинд бид нар Монгол Улсын Хөгжлийн загварыг боловсруулахад Засгийн газрын байгууллагууд хоорондоо хүчээ нэгтгэх шаардлагатай. Хөгжлийн бодлогыг тодорхойлох нь аль нэг яам тамгын газруудын өөрсдийн хүчээр хийх ажил биш. Энэ бол тооцоо судалгаатай, шинжлэх ухааны үндэстэй байх ёстой учир судалгааны байгууллагуудаар хийлгүүлэх шаардлага үүсч байна. Энэхүү судалгааны тинк, танк институцийг давхар байгуулах, эрдэмтэн судлаачдыг татаж оролцуулах шаардлагатай байна. Үндэсний Хөгжлийн газар энэхүү хэлэлцүүлгээр яригдсан асуудлуудыг дэмжиж ажиллах болно.



**Ж.Должинсүрэн**

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн захирал, Үндэсний хөгжлийн газар



**Ж.Үнэнбат**

Монголын Банкны Холбооны гүйцэтгэх захирал

Улаанбаатар зөвшилцлийн зарчмуудын бүтэцтэй холбоотой санал байна. Зөвшилцлийн зарчмуудыг тодоор тунхагласан байдлыг илүү дотор нь задалж тайлбарлах шаардлагатай. Нэр томъёоны хувьд агуулгын хувьд энэ дотроо ямар асуудлуудыг багтааж байгаа болох талаар тайлбарлах хэрэгтэй. Аль болохоор энгийн бүх хүнд ойлгогдохоор байвал. Заавал эдийн засагчдийн дунд гэхгүйгээр зохион байгуулбал илүү зүйтэй юм. Зөвшилцлийн зарчмуудын хувьд хоёр зарчим нэмэх саналтай байна. Нэг нь төрийн оролцоог багасгах хувийн секторын оролцоог нэмэх. Хоёрдугаарт нь гэрээний үүргийг биелүүлдэг хуулийг хэрэгжүүлэх мөрддөг зарчим оруулах.

Зөвшилцлөөс санал болгож буй зарчмуудаас томоохон аж ахуйн нэгжүүд бий болгох саналыг ихээр дэмжиж хүлээж авч байна. Үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд хөгжиж байж ЖДҮ хөгжинө гэж хардаг. МҮХАЖТ-аас гаргадаг томоохон аж ахуйн нэгжүүдийн шалгаруулалтыг үндэслээд ТОП аж ахуйн нэгжээ дэмжих нь зөв. Манай банк болон Монголын банкны холбооны зүгээс энэхүү санаачилгад нэгдэж, дэмжиж ажиллахаа мэдэгдэж байна. Үүнтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэр бусад асуудалд Монголбанк анхаарал хандуулж түүчээлэн ажиллана гэдэгт найдаж байна. Ажилд нь амжилт хүсье.



**О.Банзрагч**

Улаанбаатар Хотын банкны тэргүүн дэд захирал



## Н.Дашзэвэг

Монгол дээд сургуулийн захирал, гавьяат эдийн засагч

**Одоо Монгол Улсын эдийн засаг толгойгоо нийлүүлээд зөв бодлого, зөв эхлэлийг гаргах хэрэгтэй байна.**

Бид нар өнөөдөр эдийн засгийн өсөлтийг ярьж байвч ДНБ-ийг чанар болон бүтцийн талаас нь задалж чадахгүй байна. Манай эдийн засаг үр ашиггүй, бүтээмж муутай болсон байна гэж үзэхээр байна. Монгол Улсад 1,200,000 хүн ажилладаг. Үүнээс давхардсан тоогоор 450,000 үйлчилгээ, 350,000 хөдөө аж ахуй, 200,000 худалдаа, 250,000 аж үйлдвэр, 200,000 төсвийн байгууллагад ажиллаж байна. Бид нар нэгдүгээрт 1,200,000 хүмүүсийг хэрхэн байршуулах тал дээр загвар гаргах хэрэгтэй. Энгийн загвараар үйлчилгээний салбарын 450,000 хүнээс 200,000 нь аж үйлдвэрлэл, худалдааны салбарын 200,000 хүнээс 100,000 нь экспортын загвар руу шилжвэл бид нар маш бүтээмж өндөртэй, өндөр цалинтай байх боломжтой. Одоо бид эдийн засгийг цалингаар удирдах болсон. Эдийн засгийн өсөлтийг үр ашгийн өсөлтөөр хэмждэг. Үр ашгаар өсөж буй өсөлт эдийн засгийн хэдэн хувийг хангаж, тоон өсөлт хэдэн хувийг хангаж байна гэх үзүүлэлт маш чухал юм. 500 сая тонн нүүрс экспортод гаргасан гэдэг дүн бол эдийн засгийн өсөлтийг тоогоор илэрхийлж буй явдал. Бид үүний оронд нүүрс боловсруулж, бүтээмжийг сайжруулж, тээвэр логистикийг сайжруулах ажил хийх хэрэгтэй. Тиймээс бид ойрын 5 жилд бүтээмжийн асуудлыг маш хүчтэй тавих хэрэгтэй байна. Ингэж уулзаж байгаа нь маш чухал хэрэг боллоо.

Одоо Монгол Улсын эдийн засаг толгойгоо нийлүүлээд зөв бодлого, зөв эхлэлийг гаргах хэрэгтэй байна. Эдийн засгийн хөгжлийн яам үүнийг зангидах ёстой. Зах зээлийн эдийн засагт бол эдийн засгийн төлөө хариуцлагыг Төв банк хүлээдэг. АНУ-ын Төв банк ажилгүйдлийн төлөө хариуцлагыг хүлээж ажилгүйдлийг 4 хувьд, инфляцыг 2 хувьд хүргэхээр зорьж байна. Эдийн засаг муудахад Төв банк нь сайжруулах тал дээр ажиллаж байдаг.

Төв банк эдийн засагт буй том хүчинтэй тэмцэх чухал үүрэгтэй. АНУ-ын Төв банк бодлогын хүүг 1.5, 2 хувьтай барьж эдийн засгаа зохицуулж байна. Монголбанкны үүрэг яг ийм байх хэрэгтэй. Монголбанк инфляци ярьдаггүй, зөвхөн бодлогын хүү, зээлийн хүү, мөнгөний үнэ цэнэ ярьж байх хэрэгтэй.

Энэхүү “Улаанбаатарын Зөвшилцөл”-ийг “Улаанбаатарын эдийн засгийн клуб” болгож сард нэг удаа уулзаж байя. Тэгэх юм бол бид нар байр сууриа илэрхийлж гарцыг олох боломжтой.

Арилжааны банкуудын цэвэр ашгийн түвшин маш өндөр байдгийг бид мэднэ. Жилийн 24 хувийн хүүтэй зээл авсан хүн 18 хувийн ашигтай бизнесээрээ тэрхүү зээлээ төлөх ямар ч боломжгүй. Тийм учраас миний зүгээс зээлийн хүүгээр хэлэлцүүлэг хийх саналтай байна. Зээлийн хүү бол Монголбанкны үндсэн бодлого. Зээлийн хүү буурмагц инфляци дагаад буурна. Инфляци, зээлийн хүү, хадгаламжийг хүү буурмагц Монголбанкны бодлогын хүү ажиллаад эхэлнэ. Зээлийн хүүг бууруулах бол Монголбанкны хамгийн том зорилт байх ёстой болов уу гэж харж байна. Бусад оронд инфляцыг зах зээлийн өрсөлдөөнөөр бууруулдаг туршлага байдаг. Харин манай улсын хувьд зээлийн хүүг бууруулсан ч хадгаламжийн хүү өндөр байна. Тиймээс төрийн зохицуулалт хийх хэрэгтэй. Энэхүү хэлэлцүүлгээс бид нэгдсэн ойлголттой болж түүнийгээ сайжруулж боловсруулаад УИХ-д өргөн барих хэрэгтэй гэж үзэж байна. Эдийн засгийг бодлогыг зөв замд нь оруулъя.

Бидэнд зайлшгүй хэрэгтэй байсан асуудлыг хөндөн энэхүү хэлэлцүүлгийг санаачлан зохион байгуулж буй Монголбанкны удирдлагад талархлаа илэрхийлье.

Бидний ярилцаж буй энэ бүх зүйл эцэстээ тушаал шийдвэр болж гардаг. Тиймээс энэ тушаал шийдвэрүүдийг хэрхэн зөв үед, зөв шийдвэрийг гаргах тал дээр бодолцох хэрэгтэй. Өнгөрсөн цаг хугацаанд алдсан зүйл олон ч, тэдгээрээс сургамж аваад цаашдаа эдийн засгийн үндэслэл шинжилгээтэй, зах зээлээ мэдэрсэн тушаал, шийдвэрүүдийг гаргаж байх хэрэгтэй байна. Монгол улс болон бусад хөгжиж буй орнуудын өсөлтийн хандлагын хол зөрүүтэй байдал бол бидний анхаарах ёстой бас нэгэн чухал асуудал. Бусад хөгжиж буй орнуудын хувьд сүүлийн хэдэн жилийн эдийн засгийн өсөлтийг харахад тогтвортойгоор жилд 5 орчим хувьтай байна. Харин манай улсын хувьд тус үзүүлэлт маш тогтворгүй. Энэ нь биднийг цаашид аливаа шийдвэр гаргахдаа улс төрийн нүдээр харж биш, мэргэжлийн зөвлөгөөг сонсож улс орноо урт хугацаанд хэрхэн тогтвортой хөгжүүлэх вэ гэдэгт анхаарах хэрэгтэйг сануулсаар байна.

Аливаа улсын хэрэгжүүлж буй бодлого дотор төсвийн болон мөнгөний бодлого бол суурь бодлого мөн хэдий ч энэ хоёр бодлого бүх зүйлийг шийдэж чадахгүй байна. Үүнийг бүх улсын түүх харуулдаг. Тиймээс дөрвөн гол бодлогыг цогцоор нь хэрэгжүүлэхийг санал болгож байна. Үүнд мөнгөний бодлого, төсвийн бодлого, санхүүгийн зах зээлийн бодлого, бүтцийн өөрчлөлтийн бодлого. Төсөв, мөнгөний бодлого хэчнээн зөв байлаа гээд, зүйрлэж хэлэхэд хөдөлгүүр хэчнээн сайн ажилласан ч эргэх ёстой дугуйндаа хүрч чадахгүй байна. Тэгэхээр улсын мөнгөний болон төсвийн зөв бодлого зохих сувгаараа дамжин бодлогын үр дүнг хүртэх ёстой салбар, ААН-үүддээ хүрч ажиллах ёстой. Тэр завсарт бодлогыг хэрэгжүүлж байгаа эд эс нь цаг хугацааны хувьд хоцрогдон, төсөв ба мөнгөний бодлоготой ижил түвшинд хүрч хүчээ аваагүй байна. Тэгэхээр бид энэ дөрвөн бодлогыг ижил түвшинд ач холбогдол өгч хөгжүүлээгүй тохиолдолд бүтээмжийг өсгөх, технологийн дэвшлийг бий болгох асуудлууд хөгжихгүй орхигдоно. Тэгэхээр Засгийн газар дээр хэчнээн том төсөл байлаа гээд хэрэгжих боломжгүй болно. Жишээ нь: Шинэ нисэх буудлын төсөл хэрэгжиж эхлээд арав дахь жилдээ, бүтээн байгуулалтын ажил эхлээд тав дахь жилдээ явж байна. Гэвч ихэнх төслүүд дөрвөн жилийн хугацаатай байдаг, тав дахь жилээсээ мөнгөө эргүүлж төлнө гэж бичсэн байдаг. Тиймээс бид бүтцийн өөрчлөлтийн бодлогыг цогцоор нь хөгжүүлэх хэрэгтэй байна.

Мөн урт хугацааны таамаглал, прогноз дээр бид анхаарал харндуулах хэрэгтэй. Монгол банк, Сангийн яам чиг үүргийн дагуу дунд болон урт хугацааны прогнозуудыг хийдэг ч улсын хэмжээнд урт хугацааны прогнозыг олон улсын түвшинд хийж түүндээ чиглэсэн бодлого хэрэгжүүлж чадахгүй байна. сүүлийн жилүүдэд түүхий эдийн үнийн савалгаа, байгаль цаг уурын өөрчлөлт нь манай улсын эдийн засгийн тогтворгүй байдал, уналтын гол шалтгаан болж байсан. Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан эрсдэлийн тайланд хамгийн том эрсдэл бол байгаль цаг уурын эрсдэл гэсэн. Манай улсын хувьд уул уурхай, ХАА-д суурилсан учраас эдгээр салбарынхаа эрсдэлийг тодорхой хугацааны өмнө прогноз хийж чаддаг болох нь бидний хувьд том ололт болно. Дэлхийн аль ч улсад газар хөдлөлтөөс бусад бараг бүх зүйлийг таамаглах боломжтой болж байна. Манай экспортоор гаргаж буй түүхий эд харьцангуй савлагаа багатай. Жишээ нь өндөр хөгжилтэй орнууд цаг уурын шинжилгээндээ маш их анхаардаг. Тэдний хувьд нэг сарын цаг уурын прогноз бол зүгээр л мэдээ. Харин түүнээс цаашаа, 3 сар, 6 сар, дараа улирлыг прогнолох нь тэдний шийдвэрлэх гэж оролдож буй зорилт юм. Үүнтэй адилаар бид эдийн засаг нийгэмдээ тулгарч болох эрсдэлийг прогнолож урт хугацааны прогнозыг бүх салбар, түвшинд жигд хөгжүүлж чадсанаар тогтвортой эдийг засгийн өсөлтөд хүрч чадна.



## Н.Энхбаяр

МУ-ын Ерөнхий сайдын ахлах зөвлөх

Аливаа улсын хэрэгжүүлж буй бодлого дотор төсвийн болон мөнгөний бодлого бол суурь бодлого мөн хэдий ч энэ хоёр бодлого бүх зүйлийг шийдэж чадахгүй байна.



## Т.Дорж

Шинжлэх Ухааны  
академийн дэд  
ерөнхийлөгч, академич

**Бидний гол алдаа бол популист шийдвэрүүд гаргаж байсан, мөн хууль гаргасан ч жинхэнэ шаардлагын түвшинд гаргаж чаддаггүй явдал.**

Хөгжлийн эдийн засгийн асуудал бол түүхэн хөгжлийн явцад байнга судлагдаж ирсэн, энэ дотроо төрийн оролцоо, институцийн тухай асуудал аливаа ЗГ-ын анхаарлын төвд байсан. Хөгжлийн эдийн засгийн судалгааны агуулга, зорилго нь юу вэ гэдэг асуудал бол амин чухал. Кейнс, шинэ либерализмын онол зэрэг нь бас л хөгжлийн асуудал юм. Жишээлбэл Кейнс бол нийгмийн хамгаалал, даатгал зэргийг ярьдаг. Шинэ либерализмаар нэг хүнд ногдох ДНБ, өрсөлдөх чадвар бол гол үзүүлэлт байх ёстой гэдэг. Энэ чиглэлээр явахад 70-80 онуудад ядуурал, хөдөөгийн хоцрогдол, өр зээлийн асуудал дэлхий нийтийг хамарсан. Үүнээс яаж гарах вэ, шинэ ямар үзэл баримтлал байна вэ гэж асуувал эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, мөн эдийн засгийг ахиулах боломжтой бол ахиулах нь гол арга зам юм. Үүн дотор импортыг багасгаж, экспортыг өсгөх, улс болгон протекционалист бодлого баримтлах хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд нийлүүлэлт болон эрэлтийг аль аль талаас нь дэмжиж өгөх хэрэгтэй. Нийлүүлэлт талаас, багахан зүйл бүтээгээд түүнийг олон хуваах биш, харин бий болж байгаа зүйлийг ихэсгэхийн тулд ЗГ-аас дэмжих хэрэгтэй. Үүний тулд хөнгөлөлттэй зээл олгож, бүх талаас нь дэмжье. Нөгөө талаас эрэлтийн тал нь боломжтой байхын тулд эрэлтийн талыг ч дэмжих ёстой. Ингээд аваад үзвэл эдийн засгийн бүх зүйл холбоотой байдаг. Жишээлбэл, ипотекийн зээл хүн амын хамгааллын асуудал, орон сууцтай байх гэдэг утгаараа чухал. Орон сууцыг харин дундчууд өөрийн цалингаараа, эсвэл зээлээр авна. Энэ худалдан авалтыг ийнхүү дундчууд хийдэг. Гэтэл бид үндсэн үйлдвэрээ хөгжүүлбэл гээд байгаа ч дундчуудад нь мөнгө байхгүй, мөнгөө орон сууц болон бусад зүйлд зарчихсан. Тиймээс манай хэрэгжүүлж бодлогууд бие биеэ устгаад байдаг. Үүнийг ямар байдлаар засах вэ? Үүнд таван чухал асуудал байдаг нь:

1. Засгийн асуудал
2. Үйлдвэрчний асуудал
3. Дэд бүтэц
4. Санхүүгийн систем
5. Хүний хөгжлийн асуудал

Эдгээр таван зүйлс хоорондоо нэгдэж байж үйлчлэх ёстой. Төр гэдэг бол чухал. Бидний гол алдаа бол популист шийдвэрүүд гаргаж байсан, мөн хууль гаргасан ч жинхэнэ шаардлагын төвшинд гаргаж чаддаггүй. Мөн сая хөгжлийн онолуудын талаар ярьсан хэдий ч одоогийн нөхцөлд тэдгээр онолууд дүйцэхгүй болж байна. Одоо бол глобалчлал, мэдлэгийн эдийн засаг, хүний хөгжил, байгаль орчин бол амин чухал асуудал болсон. Бид хязгаарлагдмал зах зээл бүхий Паретогийн хуулийг хүлээн зөвшөөрсөн. Мэдлэг, шинжлэх ухаан бол гарцаагүй хөгжлийн хүчин зүйл юм. Ийм гол зүйлүүд бий болсон байхад бид Монголын хөгжлийн шинэ загварыг яаж бий болгох вэ? Бид 2018 оны төсөв дээр сууж байхад 100-аад шийдвэр байсан ч хэрэгжиж байгаа нь үндсэндээ байхгүй. Нэг нам гарч ирж засаглал тогтоогоод нөгөөгөө үгүйсгэдэг. Ийм байдлаар хойдох нь урдахаа үгүйсгэсээр эдийн засгийн хүнд байдалд хүрээд байна. Засаг гараад л зээл авахыг боддог. Энэ зээлд ямар нэгэн хяналт байхгүй, түүнийг юунд зардаг мөн хяналт байхгүй байна. Ийм учраас л эдийн засаг хүнд байдалд ороод байна.

Тиймээс эцэст нь хэлэхэд, Монголыг хөгжүүлэх ерөнхий загвар байх ёстой. Ийм загварыг боловсруулаад түүнийг хэрэгжүүлэх механизмыг бодож олцгооё. Хоёрдугаарт, эдийн засгийн судалгааны байгууллага байхгүй болчихжээ. Багш нар хичээлээ зааж, төрийн ажилтнууд үндсэн ажлаа л хийдэг. Тиймээс эдийн засгийн хүрээлэнг байгуулах цаг болжээ.

Монгол улсын хувьд одоо ийм нэгэн сорилт байна. Тэр нь юу вэ гэвэл манай улсын эдийн засаг түүхий эдийн зах зээлийн үнээс хамааралтай, тэрхүү түүхий эдийн үнийн хэлбэлзлийг дагуулан мэх хийдэг улс төрчдөөс гол хамааралтай эдийн засаг.

Юуны түрүүнд энэхүү зөвшилцөлд маш их ач холбогдол өгч байгаа бөгөөд маш их ирээдүйтэй, зөв зүйтэй гэж үзэж байна. Энэ үйл ажиллагаа цаашид улам хүч авч, олон хүнийг эгнээндээ нэгтгэж, үүний хүрээнд эдийн засгаа хамгаалдаг дархлаа үүсгээд явна гэж харж байна.

Манай улс ОУВС-гийн хөтөлбөрт хамрагдсан явдал нь бид улс орноо удирдаж чадаагүйн учир хийж буй ичгүүртэй зүйл. Энэхүү хөтөлбөр дуусах үед эдийн засгийн өсөлт энэ хэвээр байвал өрийн хэмжээ буурсан, түүхий эдийн үнийн хэлбэлзэл бага хэвээр байвал төсвийн орлого тогтвортой, валютын нөөц нэмэгдсэн, төсвийн ачаалал буурсан байна гэж харж байна. Гэвч өмнөх хүндрэлтэй үеийн асуудлууд эргэн сөхөгдөх өндөр эрсдэлтэй. Энэ өндөр хэлбэлзэлтэй эдийн засагт зээлийн хүү өндөр байхаас өөр аргагүй.

Хөтөлбөр дуусахтай зэрэгцэн сонгуулийн жил эхлэх учир төсвийн зардлууд нэмэгдэж, төсвийн зардал ихэснэ гэдгийг урьдын туршлагауд харуулсаар ирсэн. Харин тэр үед Монголбанк ямар хариу арга хэмжээ авах вэ, улс төрчдийн бодлогогүй алхмын эсрэг зогсож чадах уу гэдэг асуудал хамгийн чухал. Улсын Их Хурлын гишүүд хийдэг зүйлсээ хийнэ, төсвийн зардлаа нэмнэ, одооноос тойргоороо ажиллаж хэрхэн сонгогдох тал дээрээ ажиллаж байгаа. Ийм төрлийн улс төр Монголын эдийн засгийн хамгийн том дайсан болоод байна.

Харин энэ үед Төв банк өөрийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч, Төв банкны тухай хуулийг шинэчлэн батлуулсан нь маш чухал ач холбогдолтой зүйл болж байна.

Түүнчлэн Монголбанкны хувьд инфляци нэг томоохон зорилго болж байна. Сонгуулийн жилд Монголбанкинд нэг дарамт ирдгийг бид мэднэ. Сонгуулийн жил эхлэх үед төсвийн ачаалал нэмэгдэнэ, инфляци нам дор барих шаардлагатай болно. Гэтэл УИХ-аас бодлогын хүүгээ өсгөхөд дарамт учруулна.

Тэр үед Монголбанк ямар арга хэмжээ авах вэ, Монголбанкны Ерөнхийлөгч гаргасан шийдвэртээ бат зогсож чадах уу, одоогийнх шигээ сайн байж өөрийн нэр хүндээ хамгаалж чадах уу гэдэг зүйл байна. Хэрэв тэгж чадвал сайн Ерөнхийлөгч байж түүхэнд нэрээ үлдээх, эс чадвал бусдын адил байна гэж үзэж байна.

Энэ утгаараа энэ төрлийн дархлааг сайжруулахын тулд энэ зөвшилцөл хүчээ авах хэрэгтэй. Хамгийн гол нь энд яригдаж байгаа зүйлсийн мөн чанарыг ойлгож, дан ганц онолын зүйл ярих биш, эдгээр зарчмын гол санааг ойлгон, түүндээ бат зогсож байх нь чухал. Сангийн яам мөн энэхүү хэлэлцүүлэгт чухал үүрэгтэй оролцох ёстой байсан гэж үзэж байна.

Эцэст нь нэмж хэлэхэд бидний гол зорилго тогтвортой эдийн засгийн өсөлт байх ёстой. Мөчлөг бидэнд хэрэггүй. Учир нь тогтвортой өсөлт нь эдийн засгийг урт хугацаанд сэргээх, хөрөнгө оруулагчдад итгэл төрүүлэх, бизнес эрхлэгчдэд туршлага олох, мөн урт хугацаанд инноваци дэвшүүлэх бололцоог нээж өгөх, хөгжүүлэх гэх мэт чухал үр нөлөөтэй.

ОУВС-гийн хөтөлбөрийг 6 удаа авсан нь маш ичгүүртэй зүйл шүү. Энэ нөхцөл байдал дахиад давтагдах маш өндөр боломжтой. Хөтөлбөр дуусдаг буцаад асуудлууд гарч ирдэг, түүхий эдийн үнэ байнга савладаг тэгээд дахиад нөгөө асуудлууд гарч ирэх учраас бид маш болгоомжтой байх ёстой.

Ингээд Монголбанкнаас дэвшүүлсэн энэхүү санал санаачилга, үйл ажиллагаанд нь амжилт хүсье. Баярлалаа.



## Г.Рагчаасүрэн

“Гэрэгэ Партнерс” ХХК-ын захирал

... бидний гол зорилго тогтвортой эдийн засгийн өсөлт байх ёстой ...





## О.Орхон

Худалдаа, хөгжлийн  
банкны гүйцэтгэх  
захирал

Энэхүү зөвшилцлийг зохион байгуулж буйд би маш их баяртайгаар хүлээн авч байна. Учир нь энэ бол инноваци юм. Өнөөдөр дэлхий нийт инноваци, шинэчлэл гэдэг зүйл дээр тулгуурлаж хөгжиж байна гэж би харж байна. Өнгөрснийг буруутгах нь утгагүй болж байна. Яагаад гэвэл өнөөдөр бий болсон технологийн боломжууд тэр үед байгаагүй. Тиймээс өнгөрснийг шүүмжлэхээс илүүтэйгээр өнөөдөр байгаа боломжоо ашиглаж, цаашдаа яах вэ гэдэг дүр зургаа зурах нь зүйтэй гэж би хувьдаа боддог.

Тэгэхээр энэ зөвшилцөл их зүйлийн үндэс болно гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Энэ бол санхүүгийн секторын форум эсвэл эдийн засгийн онолын мэтгэлцээн биш, харин “Улаанбаатар зөвшилцөл” буюу Монгол улсын цаашдын нийгэм, эдийн засгийн хөгжлийн концепцийн суурийг тавьж буй чухал зүйл гэдгийг ойлгох хэрэгтэй. Энэ нь зөвхөн илтгэлд томъёологдсон найман зүйлээр хязгаарлагдахгүй, үүний цаана маш том утга агуулагдаж байгаа гэж би ойлгож байна. Харамсалтай нь өнөөдөр Монголд байгаа асуудлууд наймаас их учраас үүн дээр нэмэх, системчлэх маш олон зүйл байна. Мөн нэр томъёоны хувьд ерөнхий байна. Ерөнхий учраас үүнийг цааш нь хөгжүүлэх тусам төөрөлдөнө. Учир нь эдгээр найман зарчмын асуудлыг уншаад би болон бусад эрдэмтэд, нийгмийн салбарынхан бүгд өөрөөр ойлгож байна. Тиймээс концепц бий болгоход хэцүү учраас үүнийг илүү нарийвчлах хэрэгтэй. Байгаль орчны асуудал, орлогын тэгш бус хуваарилалт, ядуурлыг бууруулах, орлогын тэгш байдлыг хангах, байгаль орчин, нийгэмдээ ээлтэй байх зэрэг асуудлуудыг зайлшгүй нэмж оруулах шаардлагатай харагдаж байна. Учир нь эдгээр асуудлууд нь дээрх судалгаанд байгаа юм шиг мөртлөө байхгүй санаанууд. Хүн бүр ямар нэгэн асуудал хэлэхэд энд байгаа найман асуудлын категорид оногдоод явах боломжтой тул тэдгээр асуудлууд хаягдаад явах магадлалтай харагдаж байна.

Миний хувьд яагаад эдийн засаг, нийгмийн хөгжлийн концепцийн суурь болно гэж би үзсэн бэ гэвэл, бид онолгүй яваад байна, онол байхгүй бол концепцгүй байна, концепц байхгүй бол бодлого байхгүй, бодлого байхгүй бол систем байхгүй, систем байхгүй бол төлөвлөлт байхгүй, төлөвлөлт байхгүй бол манлайлал байхгүй, манлайлал байхгүй бол үүнийг хийх хүн манай улсад байхгүй. Тиймээс манай улсад цаашдын 20, 30, 50 жилийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн концепц зайлшгүй шаардлагатай. Үүний эхлэлийг уг зөвшилцлөөр тавьж байна гэж бодож байна. Энэхүү эхлэлийг улам бүр хөгжүүлэхийн тулд онолын хувьд ч, практикийн хувьд ч тэр цаашдаа маш олон хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй. Урт хугацааны нийгмийн хөгжлийн концепцын үр дүнг манай ААН-үүд, ард түмэн амьдрал дээрээ үүрнэ. Тиймээс Банкуудын холбооны зүгээс, энд явуулж буй бүх зүйл нь бидний үйл ажиллагаа, бодлогод шууд холбоотой учраас үүнийг цааш нь хөгжүүлэх, батлуулах, мөрдлөг болгож ажиллахад бодит амьдралд эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн том ачааг үүрч яваа банкууд бид нар тууштай дэмжих болно гэдгийг энд албан ёсоор мэдэгдэж байна.

Хувийн зүгээс нэг зүйл нэмж хэлээд яриагаа өндөрлөө. Яагаад энэ зөвшилцөл надад таалагдаж байгаа вэ гэхээр, манай улсын одоогийн хөгжлийн концепц болохгүй байна. Нэг толгойгоос олсон орлогоор нөгөө толгойгоо санхүүжүүлэх гэж оролдоод, уул уурхайг өөрсдийн ирээдүй гэж бодсон, урт хугацааны дараа ямар ашиг авахаа тооцоолох аргагүй ийм байдлаар олон засгийн газар дамжин мэтгэлцэх нь буруу юм. Бид өнөөдөр эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоход уул уурхайд үндэслэх нь гарцаагүй. Гэвч тогтвортой санхүүжилт, сэргээгдэх эрчим хүч, биологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнс гэх мэт бүс нутгаа хангаж чадахуйц хэмжээний нөөц дээрээ хамаг хүчин чадал, хүний нөөц, эдийн засаг, нийгмийн бодлогоо чиглүүлэх ёстой. Үүний гол шийдэл бол дэлхий нийтийн инноваци, технологи юм. Гэхдээ гадны технологийг Монголд авч ирж нутагшуулах биш, харин гадны ноу-хау дээр үндэслэн Монгол технологийг бий болгох боломж бидэнд байгаа гэдэгт бүрэн итгэдэг. Тиймээс цаашдаа энэ чиглэлээр МАА, малын гаралтай бүтээгдэхүүн, нано технологи, биохими, био технологи зэрэг чиглэлүүдээр манай улс олон технологиудыг дэлхийд бий болгож түүгээрээ хүний нөөц гээд бүх зүйлээ бодлоготойгоор бэлдэж явбал тогтвортой урт хугацаанд өсөөд зогсохгүй дэлхийд олон зүйлээр манлайлсан улс болж чадна гэдэгт бүрэн итгэлтэй байна.

... өнөөдөр  
байгаа  
боломжоо  
ашиглаж,  
цаашдаа яах  
вэ гэдэг дүр  
зургаа зурах нь  
зүйтэй ...



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Энэхүү зөвшилцөл нь улс төрийн орчноос үл хамааран Монгол төрийн хөгжлийн бодлогод тусч, хэрэгжиж байх учиртай.

Иймд эрдэмтэн, судлаачид, бодлого боловсруулагч Таны санаа, бодол туйлын чухал байна. Та бүхэн бидний санал болгосон энэхүү зөвшилцлийн төслийг илүү боловсронгуй болгоход өөрийн санал, бодлоо хуваалцан ярилцаж, хамтран ажиллахыг урьж байна.